



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 52

Номгон

Чиглэл өгөх тухай


Баянхонгор аймгийн Автотээврийн төвийн барилга нь 2004 онд баригдсан бөгөөд цэвэр, бохир усны төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй, нам даралтын зуухаар халдаг, багтаамж бага, техникийн хяналтын үзлэгийн байранд том оврын автомашин орох багтаамжгүй, автовокзалын стандартын шаардлага хангахгүй байгаа, аймгийн хэмжээнд тээврийн хэрэгсэлийн тоо 20851 болж өссөн, зорчигч тээврийн ачаалал нэмэгдэж өдөрт энгийн үедээ 8 автобус хот хоорондын тээвэрт явдаг, баруун чиглэлийн улсын чанартай авто зам 2018 онд баригдаж ашиглалтад орох зэргээс хамаарч авто замын ачаалал, зорчигч тээврийн үйл ажиллагаа өргөжсөн зэрэг байдлыг ТЭМДЭГЛЭЭД

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баруун бүсийн Баянхонгор авто тээврийн цогцолбор байгуулахад шаардагдах холбогдох судалгаа тооцоог 2018 оны 2 дугаар улиралд багтаан нарийвчлан гаргаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР